

ТҮҮХ, СОЁЛ

Н. Алтанцэцэг

**ХИХ ЗУУНЫ СҮҮЛИЙН ХАГАС-ХХ ЗУУНЫ
ЭХНИЙ ӨВӨР МОНГОЛ**

Марксизм-ленинизмын онол сургаалд нийт хүн төрөлхтний түүх болон аливаа улс орны түүхийг язгуурын үнэн байдал, улиран хувьсч хөгжсөөр ирсэн бодит диалектикийн зүй тогтол дагуу шинжлэн судалж, ангич, намч зарчмын үүднээс зөв зүйтэй тайлбарлан таниулахыг эрхмийн дээд гэж үздэг. Социалист орнуудын түүх судлал, нийт марксист түүхийн ухаан нь Хятадын түүх, БНХАУ-ын үндэсний цөөнхийн түүхийн зангилаа асуудлуудыг тийнхүү шинжлэх ухааны үндэстэй судлан боловсруулах талаар ихийг хийж, олон зүйлийг нэгэнт нотлон тодруулсан бөгөөд 1940-өөд оны сүүлч, 50-иад оны үест Хятадын зарим түүхчид түүнд мөн хувь нэмэр оруулж байв. Гэтэл 1950-иад оны эцэс, ялангуяа 1960-аад оны үеэс БНХАУ-д Мао Цзэдуны гаж буруу сургаал зонхилж, маоистууд өөрийн орны түүхийг, түүний дотор нэн түрүү үндэсний асуудлыг их гүрний жанжлах үндсэрхэг дээрэнгүй үзлийн зорилгоор санаатай завхруулах болсон юм,

Маогийнхан Хятадыг ямагт ертөнцийн төв байсан, одоогийн БНХАУ-ын Төвд, Уйгур, Манж, Монгол зэрэг үндэстэн угсаатны газар нутаг, хүн ардыг хятадаас үүсэн гарч, хэзээд Хятадын «салшгүй хэсэг» байсаар ирсэн, хойшид ч зайлшгүй хятад (хан) үндэстний дотор ижилсэн уусахаас өөр хувь тавилангүй мэт дүрслэн харуулахыг оролдож байна. Тийм учраас тэд XVI зууны үеэс эхлэн Манж нарын байлдан эзлэсэн Өвөр Монгол зэрэг угсаатан бүрийг цэрэг-феодалын Манж Чин улс (XVII зуун—1911), хөрөнгөтөн-газрын эздийн Хятадын Дундад Иргэн Улс, гоминданы харгислалын үед ч гэсэн өөрсдийн сайн дураар нэгэн улс гэрийн дотор багтан нийлж, энх тунх, сайн сайхнаар оршин амьдарч байсан гэдэг буруу ойлголт төрүүлэхийг чухалчилж байна. Манж Чин улсын дотор багтаж байсан бүх үндэстэн ястан нь зөвхөн гадаадын империализмын колоничлолын эсрэг тэмцэж байснаас биш, манжийн ноёрхол, Хятадын газрын эзэд, хөрөнгөтөн, худалдаачин, түшмэдийн дарлал мөлжлөг, үндэсний тахлидлын эсрэг эрх чөлөөний тэмцэл бараг хийж байгаагүй, хэрэв тийм тэмцэл зарим үед гарах хандлага байсан бол тэр нь улс гэрийг эвдэж, угсаатан үндэстний нэгдэл нягтралыг задлах гэсэн гаднын хатгалга түлхээсийн үр дагавар, туйлын харгис үзэгдэл байв хэмээн илт мэлзэх бүлгээ. Гэтэл хятадын түүхийн үнэн байдал, үндэсний цөөнхийнх нь өнгөрсөн үе чухам ямар байв? энэ талаар маоизмын баримтлал үндсээрээ буруу бөгөөд харин марксист түүхийн шинжлэх ухаан, дэвшилт түүх судлалын нотолгоо үнэн гэдгийг бодит баримт давхар нотолж байна. Үүнийг Өвөр Монголын түүхийн зөвхөн нэг үеийн ойр зуурын хэдэн баримт ч гэсэн гарцаагүй тодорхой болгон харуулж чадна.

XIX зууны II хагасын Монгол орон, Өвөр Монгол нутаг нийтдээ феодалын тархай бутархай, хоцрогдмол байдалтай байжээ. Манжийн хаан монгол феодал ноёдын дээд эзэн гэж тооцогдож байсан бөгөөд тэдний хоорондын харилцаанд хяналт тавьж, Монголыг Хятад, Оросоос салангад

тусгаар байлгаж ноёлох бодлого явуулж байв. Манжийн засгийн газар Монголын ард түмэн дотор зуураа нэгдэн босч, чөлөөлөгдөхөөс болгоомжлон байв. Манж нар Монголд өөрийн ноёрхлыг бэхжүүлэхийн тул эдийн засаг, соёлын хоцрогдлыг даамжруулах, тархай байдлыг гүнзгийрүүлэн Монголын феодалын засаг захиргааны аппаратад нэн хатуу хяналт тавихыг зорьж байв. Гэвч монголын засаг ноёд манжийн эрх баригчдын хяналт дор хошууны дотоод хэргийг биеэ даан эрхлэх байдалтай байжээ.

Монголын ард түмэн манжийн талхидал, хятад худалдаачдын мөлжлөг, дотоодын феодалын дарлалд давхар нэрвэгдэн маш хүнд бэрх байдалтай байв.

XIX зууны дундуур Манж Чин улсад хөрөнгөтөн орнууд хүч түрэн орж, гадаадын капитал нэвтрэн, улмаар мөн зууны эцэст Хятад орон империализмын хүрээнд татагдан орж, хагас колонийн байдалтай болж ирсэн зэрэг нь Монгол орон, Монголын ард түмний амьдрал байдлыг бүр ч доройтуулсан юм.

Хятадад итериалист хүчнүүд түрэмгийлэн орж байсан үед Монгол орон аажмаар гадаад улс гүрнээс тусгаарлагдмал байдлаас гарч дэлхийн зах зээлд татагдан орох болжээ. Монголыг дэлхийн капиталист зах зээлийн хүрээнд татан оруулах явдал XIX зууны сүүлч XX зууны эхээр улам хүчтэй болж, энэ нь шууд барууны орнуудын пүүсээр буюу хятад мөнгө хүүлэгчдийн гараар дамжин явагдаж байжээ. XX зууны эхэнд Монгол нь Алс Дорнод дахь империалист гүрнүүдийн, юуны өмнө Япон, Хаант Оросын мөргөлдөөний талбарын нэг болж байв.

XIX зууны сүүлчээр барууны империалист гүрнүүд Монгол руу зөвхөн бараа таваар, худалдааны зүйл оруулж байсан бол Орос-Японы дайны (1904—1905) дараа Япон улс үйлдвэрийн газар барихад зориулагдсан хөрөнгө оруулж эхлэжээ. Япон Монголд эзлэх байр сууриа хүчтэй болгосноор зөвхөн газар нутгийн хувьд эзлээд зогсохгүй, улмаар цаашид Ази тивийг эзлэх дайны түшиц газар болгох зорилготой байжээ.

Чин гүрний зүүн хойт нутагт Японы түрэмгий ажиллагаа эхлэсэн нь Хаант Орос, АНУ зэрэг бусад өрсөлдөгч гүрнүүдийн анхаарлыг ихэд татаж байв. Монгол нутагт их хэмжээний төмөр зам тавих, ашигт малт мал, эд баялаг боловсруулах үйлдвэр байгуулах гэсэн америкийн үйлдвэрийн эздийн урьдаас боловсруулсан төлөвлөгөө нь өрсөлдөгч орнуудын хоорондын зөрчил болон тэдний хоорондын дайны улмаас нурсан байна. Энэ санаархал нь олон улсын тавцанд болон хятадад болсон үйл явдлын улмаас бүтсэнгүй.

XIX зууны эцэс XX зууны эхнээс Өвөр Монголд империалист хүчин нэвтрэх үед, Хятадын мөлжимтгий худалдаа, мөнгө хүүлэгчдийн үйл ажиллагаа улам идэвхжиж иржээ. Арвин их түүхий эд, мал аж ахуйн бүтээгдэхүүн гадаадад гарах болсон нь тэгш биш арилжааг нэмэгдүүлж, ард түмнийг хоосруулж, дааж давшгүй өр ширэнд ороход хүргэжээ.

Гадаадын капитал Өвөр Монголд нэвтэрсэн нь феодалын нийгмийг задалж, хүн амын бүх давхрааны нэгэн хэсгийг аажмаар таваар мөнгөний сонирхолд татан оруулах болсон юм. Монголд нэвтрэн дэлгэрсэн хятадын худалдаа, түүнчлэн мөн хөрөнгөтөн гүрнүүдийн капитал нь ардын хувиа аргацаасан аж ахуйн суурийг эвдэж, зарим талаар таваар мөнгөний харилцаанд хөтлөх хандлага байв.¹ Тэр үеийн Манж гүрэнд хэрэглэгдэж байсан мексик доллар, орос рубль, хятад лян гүйлгээний мөнгөний нэгж болж байв. Татвар түрээс төлөх, худалдаа наймаа хийхэд эд агуурсаар солилцах явдал мөнгөний хэлбэрт шилжиж эхэлжээ. Үүний улмаас мөнгөний шаардлага феодал ноёдод, түүнчлэн ардуудад ч их болж иржээ. Гэвч хувиа аргацаасан аж ахуйн суурийг хөндсөн төдийгөөр Өвөр

1 БНМАУ-ын түүх, дэд боть, Улаанбаатар, 1968, 225-р тал.

Монгол дахь худалдаа, мөнгө хүүлэх капитал феодалын нийгмийн үйлдвэрлэлийн аргын үндсийг өөрчилж чадсангүй. К. Маркс бичихдээ: Мөнгө хүүлэл нь Азид байгаа хэлбэрээрээ эдийн засгийг улам унагааж, улс төрийн ялзралыг буй болгохоос өөр ашигтай юу ч хийхгүйгээр маш удаан тогтож чадах юм² гэжээ.

Таваар мөнгөний харилцаа хөгжиж эхлэсэн нь хувиа аргацаасан аж ахуйн хөдөлгөөнгүй байр суурийг ганхуулж чадсан ч Монголд капиталист харилцаа бий болгох нөхцөл бүрдүүлээгүй. Учир нь:

Нэгдүгээрт, таваар мөнгөний харилцааны хөгжил нь Өвөр Монголын эдийн засгийн дан ганц өөрийн хөгжлийн явцаас үүсээгүй, өөрөөр хэлбэл, худалдааны арга ажиллагаа гол төлөв гадаадын пүүс, нутгийн оршин суугчдын хооронд энгийн бараа арилжааны хэлбэртэй явагдаж байв.

Хоёрдугаарт, таваар мөнгөний харилцааны хөгжилд феодалын нийгмийн үйлдвэрлэлийн хуучин бүх дэглэм ноёрхож байжээ. Үүнд: хамжлага ард өөрийн аж ахуйн бүтээгдэхүүний ихэнх хэсгийг феодал ноёдод алба татварын хэлбэрээр төлөх буюу гадаадын пүүсүүдэд феодалын хийсэн өрийг төлөх үүрэгтэй байв. Засаг ноёдын хошууны хоорондын харилцаа холбоо сул, үндэсний зах зээл байхгүй байв. Гар үйлдвэрийн хөгжлийн төвшин доогуур, аж ахуйн салбарт гарсан алив шинэ санаачлагыг дарж байсан байна.

Гуравдугаарт, Монголын газар нутаг олон улсын усан болон төмөр замаас алслагдсан байв.

Манж гүрэн, Монгол оронд империалист хүчин нэвтрэн, түүний үйл ажиллагаа идэвхжээд ирэхийн хамт Манжийн засгийн газар, хятадын хөрөнгөтөн, газрын эздийн зүгээс Монголын нутаг дэвсгэрийг улс гүрний ерийн нэг муж болгох зорилгоор «шинэ засгийн бодлого» гэгчийг яаравчлан явуулах болов. Чин гүрэн улс төрийн чиг шугамаа өөрчилсөн нь «шинэ засгийн бодлого» хэмээх нэрийн дор алдаршин Монголд 1906 оноос эхлэн явагдах болж, юуны өмнө Өвөр Монголыг эрс өөрчлөн хятадчилахад чиглэгджээ.

XIX зууны хагасаас эхлэн манжийн эрх баригчид XVII зуунаас Өвөр Монголд мөрдлөг болгож байсан хууль дүрмээ өөрчилжээ. Манж нар XVII зууны I хагас, XIX зууны тэргүүн хагаст монгол нутагт хятадуудыг ирж худалдаа хийхийг урьд адил хязгаарлан хориглож байсан юм.³ Гэвч 1878 онд манжийн засгийн газар хятад худалдаачид, мөнгө хүүлэгчдийн өвөр Монголд хийх худалдааны үйл ажиллагааг хязгаарлах байсныг өөрчилж чөлөөтэй худалдаа хийлгэх болгосон байна.

Манжийн «Шинэ засгийн бодлогыг» амьдралд хэрэгжүүлэх өөрчлөлтүүдийн нэг арга хэмжээ бол Өвөр Монголын засаг захиргааг хятадчилж, түүний удирдлагыг хятад системд оруулахад чиглэгдэж байв. Өвөр Монголын хошууд хятад чжоу, сянь, тин гэж хуваагдан нэрлэгдэх болов. Жишээ нь: 1903 онд Түмэд, Харчин хошууны газар нутаг Фу сянь гэж хятадаар нэрлэгдэх болжээ. 1904 онд Жалайд хошуунд шинэ засаг захиргааны нэгж байгуулж Далай тин гэж нэрлэж, Хорчин баруун гарын өмнөт хэсэгт Кайтун, Цзиньвань, Хорчин баруун гарын хойт хэсэгт Гуанчи сянийг тус тус байгуулжээ.⁴

Манжийн засгийн газар Өвөр Монголын хан, ноёдын эдэлж байсан олон чухал эрхийг хасч хязгаарлан, монголын феодалуудыг засаг захир-

2 К. Маркс, Ф. Энгельс, Соч. т. 25, изд. 2, с. 146.

3 БНМАУ-ын түүх (1604—1917), дэд боть, Улаанбаатар, 1968, 214-р тал. ,

4 С. Рэнцэнсоном, Өвөр монголын түүхэн амьдрал, (гар бичмэл) 18-р тал.

гааны хувьд Бээжингээс хамааруулах явдлыг хүчтэй болгох зорилт тавьж байв. Өөрсдийн байр суурийг Монголд бататгахын тулд Манжийн засгийн газар цэрэгт өөрчлөлт хийж эхэлжээ. 1901 оны зун Манжийн засгийн газар Хятадаас Өвөр Монголд цэргийн хүч оруулж, монгол цэргийг хятад цэргийн дарга нараар удирдуулах заалт гаргаад «...Манжийн хаан Жирэмийн чуулганы захирагчид: Үүнийг (заалтыг) биелүүлэхийг тулд Жирэмийн чуулганд «шинэ боловсролын» цэргийн дарга нар ирэх гэж байна. Тэдний тусламжтайгаар цэргийн штабууд болон цэргийн шинэ боловсон хүчнүүд бий болох бөгөөд чуулган бүрд цэргийн сургууль байгуулагдах юм» гэж таниулж байжээ.⁵ «Шинэ боловсролтой» цэргийн дарга нараас гадна Өвөр Монголын «хил хязгаарыг хамгаалах» нэрийдлээр олон тооны хятад цэрэг орж иржээ. 1905 онд Барга дахь Монголын хилийн цэргийг хятад цэргүүдээр сольсон байна.⁶ Өвөр Монголын газар нутагт хятад цэргийн тоо олширч ирэхийн хамт шинэ боловсролтой цэргийн дарга нар, Монголын газар нутгийг хамгаалах нэрийн дор монгол цэргийг удирдах ажилд шургалан орох болов. «Шинэ засгийн бодлогын» Энэхүү арга хэмжээ монгол засаг ноёдын өөрсдийн цэргийг удирдах үүргийг багасгаж манж-хятадын цэргийн эрхтнүүдийн гарт шилжүүлэх зорилготой байв.

XIX зууны сүүл-XX зууны эхэнд Өвөр Монголд нэвтрэн ирэх хятадуудын тоо эрс олширсон нь Манжийн засгийн газраас 1898 онд Өвөр Монголыг колоничлохыг албан ёсоор зөвшөөрсөн⁷ явдалтай холбоотой юм. Тэр үеэс Өвөр Монголын газар нутгийг илэн далангүй түрэмгийлэн эзэлж эхлэсэн юм. Энэ явдал Монголын ард түмний биеэ даасан байдлыг хамгаалах гэсэн үндэсний шударга үзэл санааг хөндсөн юм. Иймээс монгол, хятадуудын хооронд мөргөлдөөн байнга гарч байжээ. Манж, хятадын эрх баригчид Монголын ард түмнийг нүүдэллэн ирсэн үй олон хятадуудын дунд уусгахыг зорьж байв.

Монгол газрыг хятадуудад худалдах үнэ тогтоогдож, их хэмээний бэлчээрийн газар хятад иргэдийн гарт орох болов. 1902—1908 онд хятад иргэд Өвөр Монголд шинээр 7 сая му газар хагалбарлажээ.⁸ 1908 оны хуучин улирлын 3-р сарын 17-ны өдөр Ордосын Отог хошууны монголчуудаас манжийн захиргаанд гаргасан заргын бичгийн дотор тэр тухай дурдсан нь: «...хонууны онгон догшин газар бэлчээрт иргэчүүд (хятадууд—Н. А) олшрон ирж, өвгөд онгодын шарил хүүрийг эрхүү (ухаж төнхөхи Н. А.) ба овоо, сүмийн хориул бөгөөд голомт нутгийг эвдэлж, улаан шар шороо гаргаж олон зүйлийн эрдэнэ эмдийн (эмийн ургамлын-Н. А.) үндсийг тасалснаар ...ган галав, гамшиг зовлон дэгдсэн тайж, харцас бид амь биеэ тэжээж, аж төрөн суухад туйлын бэрхшээлтэй болсон»⁹ гэжээ. XX зууны эхээр Өвөр Монголын газар нутгийг колоничлох явдал хүчтэй болж ирсэн нь нэг ёсондоо газаргүйдсэн хятадуудыг газраар хангаж байв. Өвөр Монголыг колоничлох явдал зөвхөн газар нутгийг хятадуудаар дүүргээд зогсоогүй, хотуудад хятад дэлгүүр, банк, худалдааны хороо, зам сүлжээний товчоо зэрэг албан газрууд байгуулагдаж тэдгээрт хятад иргэд ажиллах болов. Түүнчлэн ашигт малтмал гаргаж авах ажил өргөн явагдаж байв.

БНМАУ-ын ШУА-ийн Дорнодахины судлалын хүрээлэнгийн номын сан.

5 Ю. Купелев, Монголия и монгольский вопрос, С-Петербург, 1912, с. 56.

6 Новая история Китая, М., 1972, 273-р тал

7 Мөн тэнд, 459-р тал

8 Новая история Китая. М., 1972, 459-р тал,

9 Henry Struys. Documents from Ordos on the "Revolutionary Circles" "Journal of the American Oriental Society", vol. 98 (III), January-Marck 1978, p. 1-2

Манжийн хаад хувийн ашиг сонирхлын хойноос хөөцөлдсөн Өвөр Монголын феодалуудын урван тэрслэгч үйл ажиллагаанд түшиглэн тэднийг цол хэргэмээр худалдан авч, тэднээр дамжуулан «шинэ засгийн бодлогыг» амьдралд хэрэгжүүлэх болжээ.

Үй олон хятадуудыг Өвөр Монголд чөлөөтэй нэвтрүүлэх болсон явдал их хэмжээний бэлчээрийн газрыг эзлэн хагалбарлахад хүргэж, ардуудын мал аж ахуйд хохирол учруулах болсон юм.

Манжийн төрийн «шинэ засгийн бодлого» Монголд манж, хятадын засаг захиргааны ролийг ихэсгэж, нутгийн засаг ноёдын эрхийг хомстгон, хятад цэргийн тоог их болгох зэргээр илэрхийлэгдэж байлаа. Манжийн засгийн энэ бодлого нь Монголыг хүчээр колоничлох явдал байв. Энэ бүхэн Өвөр Монголын ард, феодалын дургүйцлийг хүргэхгүй байж чадсангүй. Өвөр Монгол дэлхийн капиталист зах зээлд татагдан орж эхлэх үед Манжийн «шинэ засгийн бодлого» түүний эдийн засгийг улам хямралд оруулав. Монголын мал хятадын болон гадаадын пүүсүүдийн өрийн төлөөс болж, гадагш гарах болсон хийгээд их хэмжээний бэлчээрийн газрыг хятадуудад алдах болсонтой холбогдон малын тоо эрс буурч, аж ахуй уналтанд оров. Манж ноёд, хятад газрын эзэд, худалдаачин нар байтугай атар хагалбарлах нэрийдлээр Өвөр Монголд олноор түрэгдэн орж ирсэн хятад тариачдыг хүртэл монголчууд гадаадаас (Цагаан хэрмийн цаанаас) цагаачилж ирсэн өөрийн биш хүмүүс гэж үзэн, заргын бичиг, өргөдөл гомдлынхоо дотор тэднийг тухайлан гагцхүү «харьтан иргэд»¹⁰ (Foreign chinese-харь хятад) гэхээс өөрөөр нэрлэхгүй байсан нь их л учиртай юм.

XIX—XX зууны заагт монголын феодалуудын дарлал мөлжлөг болон манж, хятадын үндэсний дарлал ширүүсч, империалист гүрнүүд, хятадын мөнгө хүүлэгчдийн тонон дээрэмдэх үйл ажиллагаа ихэссэнтэй холбогдон Өвөр Монголын үйлдвэрлэх хүчин, эдийн засаг, соёлын хөгжил ихэд саатаж, ард түмний амьдрал туйлын хүнд байдалтай болжээ. Тэр үеийн өвөр Монголын ардын зарга бичгийн дотор хошуу нутгийг дааж давшгүй өр ширэнд оруулсан хятад иргэдийн тухай бичихдээ: «Энэ нь муу иргэд нар (хятадууд—Н. А.) цагийн байдлын хүчийг хэрэглэж Монгол хүнийг дарласан нь туйл-дор хүрчээ»¹¹ гэсэн байдаг.

Энэ бүхэн Өвөр Монголын үндсэн оршин суугчид болон манж-хятадын мөлжигчид, гадаадын империалист түрэмгийлэгчдийн хоорондын зөрчлийг хурдасгажээ. Монголын феодал, манжийн эрх баригчдын болон хятадын мөнгө хүүлэгч худалдаачид, гадаадын капиталист түрэмгийлэгчдийн хэмжээлшгүй дарлал мөлжлөг ард түмнийг машид үгүйрүүлэн хоосруулж, улам шийдвэртэй тэмцэл хийхээс өөр замгүй болгож байв.

XIX зууны хоёрдугаар хагас-XX зууны эхний үеийн ард түмний тэмцэл нь гол төлөв империалист хүчин болон манж-хятадын колоничлогчдын эсрэг ард түмний эрх чөлөөний хөдөлгөөн юм. Ялангуяа XIX зууны эцэс XX зууны эхний ардын хөдөлгөөн нь зөвхөн феодалын эсрэг биш, ихэвчлэн империалист колоничлол, манжийн ноёрхол, Хятадын мөнгө хүүлэгчид, газар нутаг булаан авагч Хятад колоничлогчдын эсрэг шинж чанартай болж иржээ. Хятадын зэргэлдээ мужуудад гарч байсан Ихэтуаны* бослогын зарим бүлэг манжийн цэрэг болон гадаадын түрэмгийлэгчдийн залхаан цээрлүүлэгчдийн дайралтаас зугтаан өвөр монголын нутагт орж

10 Н. Serruys, дээр дурдсан зохиол, 4-р тал.

11 Н. Serruys, дээр дурдсан зохиол, 13-р тал.

* 1898—1901 онуудад хятадын хойт мужуудад гарсан империализмын эсрэг ард түмний бослого.

ирж, монголын ард түмнийг империалистуудын эсрэг тэмцэлд уриалж байжээ.

1900 оноос Өвөр Монголд империализмыг эсэргүүцсэн хөдөлгөөн их хэмжээний газар нутгийг хамрах болжээ. Империализмын эсрэг хөдөлгөөн гол төлөв Өвөр Монголын баруун хэсэгт гарч, Их зуугийн (Ордос) чуулганы ихэнх хэсэг, Улаан цав чуулганы хэсэг газар, Хөх хотын ойролцоох газруудыг хамарч байжээ.¹² Өвөр Монгол дахь гадаадын империализмын төлөөлөгчид-католик шашин нэвтрүүлэгчдийн эсрэг хөдөлгөөний нэг тод жишээ бол 1901 онд Ордосын Зүүнгар хошуунд 6, Харчин, Далад хошуунд 2 католик шашин нэвтрүүлэгчийг алж, өрнөдийн лам нарыг довтолж, тэдний сүм хийд, байшин барилгын ихэнхийг нь нурааж устгасан, Түмэд хошуунд монголын ард, хятад тариачид нийлсэн мянга орчим хүн католик сүм хийдийг шатаасан зэрэг явдал юм.

Энэ үеийн империализмын эсрэг хөдөлгөөнд феодал ангийн төлөөлөгчид оролцож байсан байна. Жишээ нь: 1902 онд Харчин хошуунд гарсан дугуйлангийн хөдөлгөөнийг тайж Сандаг удирдаж, уг хөдөлгөөнд хошууны захирагч өөрөө идэвхтэй оролцож байжээ.¹³

Манжийн засгийн газрын хятадчилах бодлогод хятадын хөрөнгөтэн пометикүүдын гүйцэтгэх үүрэг их байсан юм. Өвөр монголд манж-хятадын эрх баригчдын бодлогын дагуу явагдсан хүчирхийлэн колоничлох үйл ажиллагаа, дээр дурдсанчлан, зөвхөн монголын ард түмний биш, мөн феодалуудын дургүйцлийг хүргэх болов.

1902 онд Зуу-удын чуулганд монголчууд ба хятадын колоничлогчдын хооронд цуст тулалдаан болжээ.¹⁴ Уг бослого Зуу-удын чуулганы нутаг дэвсгэрт үй олон хятадууд орж суурьших болсноос гарчээ. Нутгийн ардууд хятад колоничлогчдын зүгээс бэлчээрийн газрыг түрэмгийлэн эзэмдэхийн эсрэг, хошууны газрыг хамгаалах зорилгоор босчээ. Гэтэл манж, хятад цэрэг ирж бослогыг даржээ.

1899 онд Жирэмийн чуулганы Засагт хошууны Тухум хэмээх газар Гамбуу, Самбуу нараар удирдуулсан ард түмний хөдөлгөөн гарч¹⁵ хятадуудыг хошуу нутагт орж ирэхийг болон хятад сянь бий болгохыг эсэргүүцэж байжээ. Үүний үр дүнд энэ газар хятад сянь байгуулагдаагүй байна.

1902 онд Үнэн хошуунд дугуйлангийн хөдөлгөөн гарчээ. Уг хөдөлгөөн 1900 онд хошууны ноён Шагдарсүрэн хувийн ашиг сонирхлын үүднээс нутгийн хэсэг газрыг хятад колоничлогчдод худалдсан явдлаас анх үүсчээ¹⁶. Үшэн хошууны ард түмэн Арвагжамц, Алтан-Очир, Пунцаг, Баянсайн¹⁷ нарын удирдлагаар манж-хятадын колоничлогчдод газар худалдахыг эсэргүүцжээ. Үүний үр дүнд худалдах газрын хэмжээ бага болсон байна.

1900 онд Жирэмийн чуулганы Жалайд хошуунд хятад колоничлолын эсрэг бослого гарчээ. Бослогод Цогдалайгийн удирдлагаар хэдэн зуун ард хамрагдаж, монгол газар хятадууд тариа тарих, газар хагалбарлахыг эсэргүүцжээ.

12 Дай Сюэ-цзи. 1900 нянь нэй мэнгү сибу дицюй гэцзу жэньминь де фаньди доучжэн (1900 оны Өвөр монголын баруун нутгийн ард түмний империализмын эсрэг тэмцэл) — «Лиши Яньцзью» сэтгүүл, 1960. № 6. 27-р тал.

13 Л. Н. Каминников, К вопросу об аратских движениях в Монголии в конце XIX и з начале XX вв. Л., 1934, с.40.

14 Мөн тэнд, 34-р тал.

15 «Монгол түүх, хэлбичиг» сэтгүүл. № 5, Хөх хот, 1958. 27-р тал,

16 А. Н. Калинин, к вопросу об аратских движениях в Монголии в конце XIX и в начале XX вв. Л., 1934, с. 37.

17 «Монгол түүх, хэлбичиг» №1, Хөх хот, 1958, 51-р тал

1904 онд хятадууд Зостын чуулганы 600 мянган десятин* үржил шимт газрыг худалдан авчээ. Хятадуудад газар худалдсан засаг ноён Удай болон мөн хошууны нутагт газар авахаар орж ирсэн хятадуудын эсрэг 600 ард босчээ.

Ийнхүү манж-Хятадын түрэмгийлэгчдийн эсрэг хөдөлгөөн Өвөр монголын ихэнх газрыг хамарч байв.

Оросын 1905 оны хөрөнгөтний ардчилсан хувьсгалын нөлөөгөөр Монголын ард түмний хөдөлгөөн улам бүр манж, хятадын ноёрхлын эсрэг шинж чанартай болж урьд урьдынхаас илүү хүчтэй өрнөв.

В. И. Лениний бичсэнчлэн Дэлхийн капитализм, 1905 оны оросын хөдөлгөөн хоёр нь Азийг бүрмөсөн сэргээв. Дундад зууны зогсонги байдалд зэрлэгшин хоцрогдсон түг түмэн сая хүн ам шинэ амьдрал, хүний хамгийн наад захын эрх, ардчилалын төлөө тэмцэлд босов».¹⁸

Өвөр Монголын ихэнх хошуунд дугуйлан бий болж зохион байгуулалтын хувьд боловсронгуй болж ирсэн байна. Үнэн хошууны 12 дугуйлан нэгдэж «төв дугуйлан» байгуулж түүнд дугуйлан бүрээс төлөөлөгчид орж байв. 1905 онд Ордосын Отог хошуунд 8 дугуйлан үүсэн бий болж үйл ажиллагаагаа үргэлжлүүлсээр байлаа. Манжийн эрх баригчдын бодлого, Хятадын түрэмгийлэгчид, феодалын дарлалыг эсэргүүлсэн бослого хөдөлгөөн энд тэндгүй гарч байв.

XX зууны эхний жилүүдэд манжийн засгийн газрын хятадчилах бодлогыг эсэргүүцсэн феодал ангийн дэвшилт төлөөлөгч Тогтох тайжийн удирдсан хөдөлгөөн ихээхэн үүрэг гүйцэтгэж байлаа. Уг хөдөлгөөн 1905 онд Жирэмийн чуулганы Горлосын өмнөд хошуунд гарчээ. Босогчид манжийн засгийн газрын бодлогонд дургүйцэж, хятадууд газар эзэмдэн авсныг эсэргүүцэн босчээ. Тогтох бослогыг удирдахдаа ард түмэнтэй нягт холбоотой байж, тэднээс их хэмжээний дэмжлэг хүлээж байв. Тогтохоор удирдуулсан бослогыг дэмжин Жалайд, Хорчин хошуудын ард түмэн хятад иргэдийн зүгээс монгол газар эзэмдэн хагалбарлахын эсрэг босчээ. Тэр үед Чанчунь, Далай, Таоань зэрэг газрууд Тогтохын босогчдын хамгаалалтанд байсан байна. Тогтохын удирдсан бослогын цэрэг нь зохион байгуулалт, арга тактикийн талаар харьгангуй сайн байсан учир Жирэмийн чуулганы хойт хэсгийг нэгэн хэсэгтээ нилээд баттай хамгаалж байжээ.¹⁹

Ийнхүү Өвөр монголын феодалууд ард түмний дургүйцэл, манжийн засгийн газрын доройтсон байдлыг ашиглан өөрийн улсыг бие даан удирдах эрхийн төлөө ард түмнийг уриалан тэмцэлд босох болов. Тэр тэмцлийн удирдлаганд гарсан Монголын феодалууд манж, хятадын ноёрхлыг устгах зорилт тавьж иржээ.

Манж-Хятадын эсрэг тэмцэл малчин ардууд төдийгүй, феодал ангийн төлөөлөгчид идэвхтэй оролцож байсан явдал энэ тэмшлийн үндэсний чөлөөлөх шинж чанартай байсныг гэрчилж байна.

Манж-Хятадын колоничлогчдын эсрэг үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнд 1905 оны оросын хувьсгал, оросын хувьсгалчдын дэвшилтэт үзэл санаа чухал нөлөө үзүүлсэн юм. Өвөр Монголын ард түмний үндэсний ухамсрыг сэргээх явдалд 1909 онд Харбинд хэвлэгдсэн «Монгол сонин» бас багагүй үүрэг гүйцэтгэсэн юм.²⁰ Уг сонин манж-хятадын эзэрхийлэгчдийн түрэмгий үйл ажиллагааны үнэн зорилго, хор уршгийг ухуулан та-

* 1 десятин= ойролцоогоор 1 га

13 В. И. Ленин. Зохиолууд, 19-р боть, 1966, 72-р тал.

19 Г. Навааннамжил, Зоригт баатар Тогтохын товч намтар, УБ., 1946, 25-р тал,

20 А. Дашжамц Монгол дахь дэвшилт ардчилсан үзлийн хөгжлийн асуудалд.

УБ, 1970, 18-р тал.

ниулж, монголын тусгаар тогтнох эрхийг хамгаалж, зарим талаар оросын дэвшилт үзэлтнүүдийн ардчилсан үзэл санааг таниулж байжээ.

1911—1912 оны Монголд гарсан манжийн эсрэг тэмцэл бол Монголын ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн байсан бөгөөд манжийн ноёрхлыг устгасан юм. Манжийн засгийн газрын бодлого, хятадын хөрөнгөтөн, газрын эздийн харгис үйл ажиллагаа нь харийн дарлалаас чөлөөлөгдөж, эх орны тусгаар тогтнолыг сэргээх гэсэн монголын ард түмний хүсэл эрмэлзлэлийг няцааж чадаагүй юм.

Дээр дурдсан зүйлээс үзэхэд доорхи дүгнэлтүүдийг хийж болох байна. Үүнд:

1-рт, Өвөр Монголын ард түмэн Манж Чин улсын ноёрхолд байхдаа, Маогийнхны өгүүлдэгчлэн, сайн дураар улс гэрийн дотор оршиж, амар тайван аж төрж байсангүй, байнга харийн дарлал, дотоодын феодалын дарлалд нэрвэгдэн маш хүнд бэрх амьдралыг туулж иржээ. Империализмын колоничлал, манжийн талхидал, феодалын дарлалын зэрэгцээ хятадын хөрөнгөтөн, газрын эзэд, худалдаачин, түшмэдийн дарлал, хятад үндэстэнд түүнийг хүчээр уусган ижилсүүлэх харгис бодлого туйлын их хор хохирол учруулсан байжээ.

2-рт, Өвөр Монголчууд империалист колоничлол, манжийн талхидал, Хятадын хөрөнгөтөн-газрын эздийн дарлал, манж хятадын уусган ижилсүүлэх бодлогын эсрэг улам улмаар идэвх зориг, зохион байгуулалттай тэмцэж, зарим үед багагүй амжилт олж байжээ. Тухайн үед харийн дарлалын эсрэг үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн ардын тэмцлийн зонхилох чиглэл болж байв.

3-рт, Манж, хятадын эрх баригчид Өвөр Монголын ард түмний тэмцэл хөдөлгөөнийг харгис хэрцгий дарж байсан боловч эрх чөлөөг эрмэлзэх зориг санааг нь мохоож чадсангүй. Өвөр Монголын ард түмэн гадаад, дотоодын дайсны эсрэг хойшид нэн баатарлаг тэмцэл хийсээр байсан юм.

4-рт. Өвөр Монгол зэрэг БНХАУ-ын үндэсний цөөнхийн түүхийн талаар маогийнхны баримталж буй үзэл үнэн байдалд үл нийлэлцэх бөгөөд түүхэн үнэн түүнийг шийдвэртэй няцааж байна. Хятадын ард түмний нэрийн өмнөөс Өвөр Монгол болон бусад хятад бус үндэстний районд Бээжингийн эрх баригчдын явуулж буй их гүрний дээрэнгүй жанжлах бодлого түүхээр өчүүхэн төдий ч үндэслэгдэх боломжгүй юм.

5-рт, БНХАУ-ын түүх, үндэстний цөөнхийн талаар маогийнхны баримталж байгаа үзэл уг чанартаа бодит байдлыг их гүрний жанжлах үндсэрхэг дээрэнгүй үзлийн үүднээс санаатай мушгин гуйвуулж, бүрмөсөн завхруулахад чиглэсэн харгис шинжтэй бөгөөд марксизмд харш учир түүн дээр тулгуурласан Бээжингийн удирдагчдын үндэстний ба дотоод, гадаад бодлого хүнлиг дэвшилтэй, бат туйлбартай, алсын ирээдүйтэй байж хэрхэвч үл болно.

Н. Алтанцэцэг

ВНУТРЕННЯЯ МОНГОЛИЯ ВО ВТОРОЙ ПОЛОВИНЕ XIX И НАЧАЛЕ XX вв.

Резюме

В настоящей статье автор, основываясь на архивных материалах МНР и исторических источниках, анализирует политику центрального правительства Китая в отношении Внутренней Монголии, а также борьбу ее на-

рода против маньчжуро-китайских колонизаторов во второй половине XIX и начале XX вв, В изучаемый период Цинский двор особенно активизирует свою политику по колонизации южно-монгольской территории и китайзации административной системы Внутренней Монголии.

Наряду с маньчжурским гнетом, колонизация Внутренней Монголии китайской буржуазией, помещиками, торговцами привела к еще большему экономическому упадку и крайне ухудшило положение скотоводов. В связи с этим монгольское население развернуло упорную борьбу против эксплуатации, за свои национальные права. Народ Внутренней Монголии в своей борьбе против жестокости маньчжуро-китайских колонизаторов, добивался немало успехов.

В 1899 году в Засагту хошуне Чжеримского сейма вспыхнуло народное восстание против перенаселения китайцев в свой хошун и создания китайского сян (уезда). В результате успехов борьбы цинам не удалось создать там китайский сян.

В 1902 году в Ушинском хошуне Ордосского сейма произошло движение народных масс против продажи части хошунной земли маньчжуро-китайским колонизаторам и благодаря этому часть проданной земли было возвращена монголам.

Движение монгольских народов против маньчжурского господства и китайской колонизации, в том числе и народа Внутренней Монголии, носило ярко выраженный характер национально-освободительной борьбы.

Под влиянием русской буржуазно-демократической революции 1905 национально-освободительное движение монгольских народов приобретало все более широкий размах и в 1911—1912 гг. вылилось в общемонгольскую освободительную борьбу, которая освободила страну от маньчжурского ига, что во многом способствовало делу дальнейшего завоевания народом независимости и суверенитета.

В заключение автор подвергает критике великодержавно-шовинистическую концепцию китайских историков, игнорирующую национально-освободительную борьбу малых, некитайских народов против маньчжур-китайских колонизаторов.